

## Хичээл №2

### СЭТГЭЛГЭЭ- БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ- ШҮҮМЖИТ СЭТГЭЛГЭЭ

#### Хичээлийн агуулга

- I. Эргэн санах,
- II. Сэтгэлгээ буюу сэтгэн бодох үйл ажиллагаа,
- III. Бүтээлч сэтгэлгээ,
- IV. Бүтээлч сэтгэлгээ ба шүүмжит сэтгэлгээ
- V. Бүтээлч хүн
- VI. Даалгавар

#### I. ЭРГЭН САНАХ, ДЭЛГЭРҮҮЛЖ ОЙЛГОХ:

##### *Бүтээлч үйл ажиллагааны явц, үе шатууд*

Эртний Грек, Ромын суутнуудаас аваад өнөөгийн Нобелийн шагналтнуудын бүтээлээ туурвисан түүх, тэдний туулсан замыг судалсан эвристикийн судлаач эрдэмтэд бүтээлч үйл ажиллагааны систем, үйл явц, үе шатыг ерөнхийлж гаргасан байдаг.

1. **Эхэн үе** – асуудал, бодлогын нөхцлийг тодорхойлоод анхны оролдлого хийх,
2. **Инкубацийн үе** – асуудлын шийдлийг түр хойшлуулж, бодож боловсруулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх,
3. **Шийдэл гэрэлтэх** – оюун ухаанд оршсоор байсан асуудлын шийдэл гэнэт орж ирнэ,
4. **Шалгаж нотлох** - туршиж шалгаад хэрэгжүүлж, нэвтрүүлэх

##### *Үүнд:*

1. **Эхэн үе** – асуудал, бодлогын нөхцлийг тодорхойлоод анхны оролдлого хийх  
Энд яригдаж байгаа асуудал гэдэг маань аливаа шинээр хийж, бүтээж бий болгох гэж буй зүйлийн сэдэл, учир шалтгааны тухайт асуудлыг буюу бидний шийдвэрлэх асуудлыг хэлж байгаа юм. Энэ асуудлыг ерөнхийд нь хоёр төрөлд хувааж үзэж болмоор байна. 1-рт, болзмол шинжтэй асуудал, 2-рт, өмнө нь дэвшигдсэн асуудлын шийдлийг эрж хайж байх явцад үүссэн асуудал. (Мая Анжелу: “Та өөрийн бүтээлч сэтгэлгээний ундаргаа ашиглаж дуусгахгүй. Учир нь та илүү их хэрэглэх тусам танд илүү ихээр ирнэ”)
2. **Инкубацийн үе** – тухайн асуудлаас түр хугацаагаар хөндийрөх: Энэ нь шийдэх асуудлаа ор тас орхиод хөндийрчихөнө гэсэн үг. Зөвхөн тэр асуудлаа анхаараад өөр бусад ажлуудаа орхино гэсэн үг ч биш. Бусад олон ажил төрөл, асуудлаа шийдэхийн зэрэгцээ нөгөө шийдлийг нь олох асуудлаа бодож боловсруулсаар л

байхыг хэл байгаа хэрэг.

Алдарт Леонардо да Винчи Мона Лизагаа 16 жил зурсан гэдэг түүхийг эргэн санаж, дахин судлаарай!

3. **Онгод орж Гэрэл гийх** – оюун ухаанд оршоор байсан асуудлын шийдэл гэнэт орж ирнэ.

Үүнийг гэнэтийн, ид шидийн юм шигээр ойлгож болохгүй. Урт хугацааны туршид бодож боловсруулсаар байсан үйл явцын үр дүн юм. Бүтээлч сэтгэлгээ нь суурь мэдлэг туршлага дээр суурилсан урт хугацааны хөдөлмөр, сониуч зан, олон янзын оролдлого туршилтууд, хичээл зүтгэлийн үр дүн эцэстээ гэнэтийн гэмээр сайхан шийдэл авч ирдэг.

4. **Шалгах** - туршиж шалгаад хэрэгжүүлж, нэвтрүүлэх

Нэгэнт шийдэгдсэн асуудаа олон янзаар туршиж, баталгаажуулж хамгийн эцсийн шийдэлд хүрч хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгох.

## II. СЭТГЭЛГЭЭ БУЮУ СЭТГЭН БОДОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



**Асуудал үүсэж асуулт гарахад, оюун ухаанаа ажиллууж шийдэл олох нь Сэтгэлгээ**

(Бүтээлч сэтгэлгээний талаас нь авч үзвэл)

Хүний бусад амьтдаас ялгарах нэг гол мөн чанар нь хүний сэтгэн бодох, төсөөлөн дүрслэх чадварт байдаг гэж түрүүн бид дурдаж байсан. Тэгэхлээр, хэл яриа, урлаг соёл, шашин, шинжлэх ухааны хөгжил, улс төрийн байдал бүгд хүний сэтгэн бодох оюуны чадвараас үүдэлтэй болж таарч байна

Бид сэтгэн бодох чадвартай учраас ажиглан сонирхож байгаа зүйлсээ задлан шинжлэх, харьцуулан жиших, нэгтгэн дүгнэх боломжтой байдаг билээ.

Иймээс сэтгэлгээ бол энгийн үгээр бол хүний танин мэдэх үйл ажиллагааны дээд түвшин юм. Сэтгэхүйн үндсэн хэлбэрүүд нь ойлголт (мэдлэг), бодомж (ухаанаа уралдуулан шүүн тунгаах), оюун дүгнэлт (гаргалгаа), адилтгал хийх үйлүүд байдаг.

Хүний бүхий л үйл ажиллагаа, тоглоом наадам, сургалт хүмүүжил, ажил хөдөлмөр, хоорондын харилцаа бүгд сэтгэхүй дээр үндэслэсэн байна. Тиймээс сэтгэхүй нь хүний зан чанар, сэтгэл хөдлөл, мэдлэг чадвар, мотиваци гэсэн хувийн шинж чанаруудтай нягт холбоотой нь мэдээж.

Тодорхой нөхцөлд үүсэн бий болсон асуудлаас шалтгаалаад сэтгэхүйн үйл ажиллагаа харилцан адилгүй хэлбэрээр явагддаг. Үүнээс нь үүдээд сэтгэхүйн процессыг (сэтгэх үйл) хэд хэдэн төрөл болгон судалдаг байна. Үүнд:

- ◆ дедуктив
- ◆ индуктив
- ◆ аналитик
- ◆ бүтээлч
- ◆ шүүмжит

*Дедуктив* сэтгэлгээгээр шийдлийг ерөнхий байдлаас тухайлсан нөхцөл рүү задлан хандах замаар хайна. Шинжлэх ухаан, анагаах, гэмт хэргийн шинжилгээнд ихэвчлэн ашиглана.

*Индуктив* нь дээрхийн эсрэг. Өөрөөр хэлбэл, хэд хэдэн тухайн тохиолдол, тодорхой элементүүдийн үндсэн дээр ерөнхий, нийтлэг дүгнэлт гаргалгааг хийдэг.

*Аналитик* сэтгэлгээгээр үзэгдэл, нөхцлийг нэлээд гүнзгий, задлан шинжилж дүгнэлт гаргана. Нарийн ширийн деталь тус бүрийг төрөл бүрээр ангилж эрэмбэлхэд ихээхэн анхаарна.

*Бүтээлч сэтгэлгээ* нь ихээхэн чөлөөтэй, задгай стгэлгээ. Бүтээлч сэтгэлгээ нь хүн бүрт адилгүй, төрөлхийн чанартай гэх боловч түүнийг бид өөртөө хөгжүүлэн эзэмшиж болно. Соёл урлагийнхан ихэнхдээ ийм төрөлхийн авьяас чавдартай байх нь элбэгийг бид мэднэ.

*Шүүмжит* (шүүн тунгаах) буюу критик сэтгэлгээгээр юмс үзэгдэлтэй холбоотой асуудлыг задлан шинжилж нэгтгэн дүгнэхийн хажуугаар өөрийн гэсэн хувийн санаа оноогоор эргэлзээтэй баримт, фактуудыг заавал шалган туршиж, үнэн зөв, ач холбогдолтой эсэх, шинэчлэх, хөгжүүлэх шаардлагатай эсэхийг мэдэх гэх мэтэд хэрэглэгдэнэ.

### Ш. БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ

Бүтээлч сэтгэлгээний гол зорилго бол шинэ санаа олох, шинэ мэдлэгт хүрч шинэ бүтээл туурвих юм. Өнөө үед бүтээлч сэтгэлгээг креатив сэтгэлгээ гэж их ярих болжээ. Сэтгэл зүйн ухаанд хүний тархины зүүн хагас нь үг хэл, ярианы болон учир шалтгаан, логикийн хэвшмэл тогтсон төсөөлөл, мэдлэгийг хариуцдаг бол харин

баруун хагас нь тэрхүү мэдлэг төсөөллийг хөдөлгөөнд оруулан ажиллуулах, үр дүнд нь шинэ мэдлэг, шинэ бүтээл төрнө гэж үздэг.



ЕБС- н физикт бидэнд зааж байсанчлан алив материаллаг биет хөдөлгөөнгүй тайван нөхцөлд идэвхгүй, ямар нэг ажил гүйцэтгэдэггүй. Харин хөдөлгөөнтэй, тодорхой хурдтай бол энергитэй, энергитэй тул ажил хийх боломжтой байдаг билээ. Ашигт ажил, ашиггүй ажил гэж бас байна.

Үүнтэй дүйцүүлэн үзвэл, бид мэдлэгээ хөдөлгөөнд оруулан ажиллуулж, түүнийгээ ашиглаж байж шинэ мэдээлэл, мэдлэг, цаашлаад шинэ бүтээл гаргана гэж ойлгож болно. Эс тэгвэл бидний төрөхөөсөө аваад эхлээд аав ээж, өвөө эмээгээсээ дараа нь цэцэрлэг сургууль, их сургууль коллежоор дамжин өнөөдрийг хүртэл түүж цуглуулсан өнөө уран баялаг үг хэл, тал бүрийн шинжлэх ухаан, соёл урлагийн талаарах өргөн мэдлэг, учир шалтгааны тайлбар, логик хууль дүрмүүд чинь гараажиндаа зэврэн зогсчихсон, залхуу эзэний түлшгүй, ганган машин мэт бус уу?

Тэгэхээр, өөрт байгаа мэдлэгээ ашиглан, логик сэтгэлгээгээ ажиллуулахдаа тогтсон хэв загвараас чөлөөтэй гарч, стандарт бус сэтгэснээр шинэ бүтээл төрнө гэсэн санаа юм. Исаак Ньютон, Дмитрий Менделеев, Зигмунд Фрейд, Леонарда да Винчи, Ван Гог, Вольфганг Моцарт, Сальвадор Дали гээд олон суутнууд яг ингэж бусдаас өөрөөр, хэвшмэл бус өвөрмөц маягаар сэтгэн боддог байсан тухай намтар түүх нь өгүүлдэг билээ.

#### IV. БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ БА ШҮҮМЖИТ СЭТГЭЛГЭЭ

*Юуны түүрүүнд хэллэг, нэр томъёон дээрээ тогтоё!*

Шүүмж бол шүүмжлэл биш. Шүүмжлэлийн үндэс нь – шүүх, шийтгэх, буруутгах буюу сөрөг сэдэлтэй үйл. Алдаа мадаг, өө сэвэн дээр нь дөрөөлөн өөнтөглөх, буруутган адлах нь шүүмжлэл. Шүүмжлэл бүр шийтгэл болон хатуурах нь ч бий. Хүмүүсийн болоод бүлэг хамт олны дунд хагаралдаан, тэмцэлдээн үүсгэх суурь нөхцөл болох ч тал бий. Ер нь шүүмжлэлийн үр дүн гол төлөв сөрөг үр дагавартай байх нь олонтой.



Харин шүүмжийн үндэс нь – шүүж тунгаах, цэвэршүүлж ариусгах, шинэчилж сайхжуулах сэдлээс үүсэлтэй үйл гэж ойлгож болно. Ингэж тохирох уу?

Тэгэхээр шүүмж гэдэг нь буруу зөвийг тунгааж шүүн бодох, алдаа дутагдлыг илрүүлэн засах, илүү сайжруулах, шинэчлэх, эдгээрийн төлөө хамтран ажиллахад хүргэх эерэг үр дагавартай.

Товчоор хэлбэл, шүүмжлэл нурааж байхад, шүүмж бүтээж байдаг гэвэл зохистой.

### ***Бүтээлч сэтгэлгээ гэдэг бол шүүмжит сэтгэлгээ.***

Эдгээр үр дагавараас нь авч үзвэл, бүтээлч сэтгэлгээ гэдэг нь аливаа зүйлийг \асуудал, нөхцөл байдал г.м.\ урьд өмнө нь авч үзээгүй, шинэ байдлаар харахад суурилдаг бөгөөд шинэ зүйл зохион бүтээх санаа шийдэл, арга ухаан юм. Аливаа зүйлийг урьд өмнө нь авч үзэж байгаагүй, шинэ байдлаар харна (өнөө үед манайхан өөр өнцгөөс харах гэж их ярьдаг болжээ) гэдэг маань тухайн зүйлд шүүмжит сэтгэлгээгээр хандана гэсэнтэй үндсэндээ утга ижил юм. Ингэж хандах чадвар та бүхэнд, ялангуяа уран бүтээлчдэд эрхэм зүйл мөн.

Өөрөөр хэлбэл, аливааг олон талаас нь харж, хуучин төсөөлөл, онолд эргэлзээтэй

хандаж, бүтээлч эрэл хайгуул хийнэ гэсэн үг.

Ямар ч эргэлзээгүй цэвэр итгэл дээр үндэслэсэн сэтгэлгээ, дуулсан мэдсэнээ өөрийнхөөрөө шинжиж цэгнэлгүйгээр шууд хийсэн гаргалгаа нь оновчгүйгээс гадна бүр алдаатай буруу дүгнэлтэнд хүргэж болно.

Харин бүтээлч, шүүмжит сэтгэлгээ нь асуудлыг нарийвчлан шүүн тунгааж хамгийн сайн хувилбарыг эрж олоход чиглэсэн байдаг.

***Сэтгэлгээний шүүмж нь дараах ач холбогдолтой:***

- мэдлэг мэдээллийг шинжиж шалган зөв сонголт хийх
- өөрийн үзэл бодол, байр суурийг товч тодорхой, ойлгомжтой илэрхийлэх
- хамтрагч болон бусдыг зөв талаас нь харж илүү сайн ойлгох
- сэтгэл хөдлөлөө хянах, удирдах
- хэрэгтэй мэдээллийг сонгон ашиглах
- хэв загвар, хэвшмэл ойлголтын нөлөөнд автахгүй байх
- орчин тойрноо, болж буй үйл явдлыг олон талаас нь харж, дасан зохицох, суралцах зэрэг олон талын ач холбогдолтой.



Английн орчин үеийн сэтгэл зүйч, техникийн философич **Том Чатфилд**

***шүүмжит сэтгэлгээний 10 зарчмыг*** тодорхойлжээ:

- 1) Яаралгүй, тайван эргэцүүлэх.
- 2) Сэтгэл, оюуныхаа хүч чадлыг гамтай зарцуул. Энэ бол таны их үнэ цэнтэй нөөц шүү.
- 3) Хэрэв эргэлзээ байвал, хэсэг хүлээсэн нь дээр.
- 4) Өөрийн чадвар, боломж хязгаартайг хүлээн зөвшөөрөх.
- 5) Эргэж нөхөгдөхгүй зардлын тухай байнга санаж, хийх хэрэгтэй эсэхийг цэгнэж байх.
- 6) Нотолгоо хайхаасаа өмнө “но”-гий нь олохыг чухалчлах. Тэгвэл зөрчил, гацаа нь тод харагдаад, таны баталгаа, нотолгоо баараагүй жинтэй, үндэслэлтэй болно.
- 7) Өнөөдрийн үр дүнгээс түрүүнд хэтийн үр дагаварыг тавьж байх.

- 8) Амжилт ололт гялалзаж байвч “алтан дундаж” бүтээж байдгийг бас санах.
- 9) Өөрийн үзэл баримтлал, үнэ цэн, хүч чадлынхаа хэмжээ хязгаарыг мэдэрдэг байх,
- 10) Эцэст нь, таны бүх хувилбарууд алдаатай, андуутай байж мэднэ шүү!  
гэдгийг онцолсон байдаг.



**Бүтээлч сэтгэлгээ ба шүүмжит сэтгэлгээ хоёр “уурга, хуйв” шиг холбоотой,  
хамтрагчид.**

Бүтээлч сэтгэлгээ гэдэг нь аливаа асуудал, нөхцөл байдлыг өөр шинэлэг талаас нь харах, шинээр өөрийн гэсэн онцлогтой шинэ зүйлийг, шинэ үнэ цэнийг олж харах, бодож сэтгэх арга юм. Шүүмжит сэтгэлгээ гэдэг нь үндэслэлтэй, дэс дараалсан сахилга баттай үйл явц бөгөөд дүгнэлт, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэлд дүн шинжилгээ хийх, оновчтой болгох, үнэлэх, тайлбарлах үйл явц юм.

Ийм бүтээлч-шүүмжит сэтгэлгээгээ хөгжүүлснээр та бид өөрийн санаа оноогоо сайн илэрхийлэхээс гадна өнөөгийн интернет, сошиалын элдэв мэдээллийн золиосонд орохоос сэргийлж чадна.

## V. БҮТЭЭЛЧ ХҮН






### ***Шинжлэх ухаанч сэтгэлгээ:***

Бүтээлч сэтгэлгээ өндөртэй хүмүүсийн тухай судлаад үзэхээр тэдгээр хүмүүс шинжлэх ухаанч сэтгэлгээтэй хүмүүс байдаг. Урлагийн алдартнууд ч ялгаагүй шинжлэх ухааны өргөн цар хүрээтэй мэдлэгтэй, шинжлэх ухаанч судалгаа хийдэг хүмүүс байдаг нь тэдний туулж өнгөрүүлсэн амьдрал, мөнхөрч үлдсэн уран бүтээл төрсөн түүхээс нь ойлгогддог. Тиймээс бид шинжлэх ухаанч сэтгэлгээний талаар ч гэсэн системтэй ойлголттой, мэдлэгтэй, уран бүтээлдээ хэрэглэж ашигладаг байх хэрэгтэй.

Өдөр тутмын амьдрал ахуй, ажил төрөл, бусадтай харилцах харилцааны явцдаа бидний олж авах мэдлэг мэдээлэл, сэтгэх чадвараас гадна бодит байдлыг тайлбарлах, танин мэдэх сэтгэлгээний тусгай арга буюу шинжлэх ухааны сэтгэлгээ гэж бас бий.

Шинжлэх ухааны сэтгэлгээнд мэдлэг мэдээлэл цуглуулах, ангилан системчлэх, шалган нягтлах, цаашид боловсруулан шинэ мэдээлэл, мэдлэг гарган авах тусгай арга аргачлал, алгоритм гэж байдаг. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны сэтгэлгээ нь ямар нэгэн асуудлын шийдийг олж гаргалгаа хийхдээ хувь хүний субъектив сонирхолыг аль болох багасгаж онолын үндэслэл, анализ синтез хийх гэх мэтчилэн олон янзын арга зүй, аргачлалын дагуу ажилладаг.

Дэлхийн хэмжээний креатив хүмүүсийн жишээг тоолоод баршгүй. Леонардо Да Винчи, Коперник, Томас Эдисон гэх мэт дэлхийн хэмжээний сэтгэгчид цаг үеэсээ илт түрүүлсэн байжээ. Орчин үеийн креатив хүмүүсийн зарим жишээ гэвэл Стив Жобс, Жоан Роулинг, Ричард Брэнсон, Элон Маск нар байна. Эдгээр хүмүүс бол дэлхийг шинэ чиглэлд хөдөлгөж оюун санааны хувьсгал хийгчид юм.



**Бүтээлч – креатив сэтгэлгээний талаар алдартнуудын хэлсэн үгс**

Эх сурвалж: <https://business.mn/blog/2020/01/08>

Гэхдээ бидэнд тэдгээр хүмүүсийн адил бүтээлчээр сэтгэж, шинийг бүтээж хийх боломж бүрэн байдаг. Харийн хүүхэд байхдаа унаган байсан тэрхүү чадвараа хүн

өөрийн хуримтлуулсан мэдлэг, туршлага, логик бодлуудаараа баглаад, хайрцагнаас гадуур буюу чөлөөтэй сэтгэх бололцоогоо эгнэгт хаадагт хамаг учир оршино. ...Бүх хүүхэд уран бүтээлч байдаг, харин том болоод уран бүтээлч хэвээр үлдэх үү, гэдэгт л гол асуудал нь байгаа юм... гэж Пабло Пикассогийн хэлсэн үгийг санаарай!

**Бүтээлч хүний онцлог шинжүүд:**



Бүтээлч хүмүүсийн сэтгэлгээ бусдынхаас ялгаатай, өнгө төрх нь ондоо.

Хүн бүр бүтээлч чанартай. Ялангуяа хүүхдүүд бага наснаасаа л аливаа шинэ бүхнийг ойлгож мэдэх, тэдгээрт суралцах, шинийг бүтээх гойд чадвартай, хүсэл тэмүүлэлтэй байдгийг бид мэднэ. Хөлд орох, хөлд орох, анхныхаа зургийг зурах, эд бүгд хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, бүтээлч үйлс юм. Харин том болох тутам элдэв дүрэм, журам, нийгмийн орчноос шалтгаалан бүтээлч чанаруудаа алдах нь бий. Тиймээс бид хүүхэд насныхаа үйл явдлуудыг эргэх санаж дурсаж байх хэрэгтэй. Ер нь хүн бага насны хөгжилтэй, бүтэлтэй бүтэлгүй зүйлсээ эргэн дурсах дуртай байдаг гэж би боддог. Бүр түүний тулд зориуд цаг гаргаж байх хэрэгтэй ч байж магадгүй. Ингэх нь бидний бүтээлч сэтгэлгээний өөрийн гэсэн онцлогоо илрүүлэхэд тус болж мэдэх юм.

***Бүтээлч хувь хүний онцлог шинж чанаруудыг сэтгэл зүйн ухаанд судалж тодорхойлсноос товч авч үзэцгээе.***

***Мөрөөдөгч***

Бүтээлч хүмүүс ихэнхдээ мөрөөдөгч байдаг. Тэдний мөрөөдөл, төсөөлөл нь бүтээлч сэтгэлгээг нь тэтгэн өдөөж байдаг.

*Тиймдээ ч бүтээлч хүний гаргасан санаа, хийсэн бүтээл нь бусдынхаас ялгаатай сонин содон, санаанд оромгүй оригинал байдаг. Ерөөсөө бүтээлч нэгэн байнга ийм зүйл рүү тэмүүлж байдаг чанартай гэж болно (Б.М).*

### ***Өөрийгөө өвөрмөцөөр илэрхийлэх дуртай***

Бүтээлч хүмүүсийг гадаад төрхөөр нь танихад амархан. Тэдний үс засал, хувцаслалт нь бусдаас ялгаатай, шивээс хийлгэсэн байх нь элбэг. Өөрийгөө илэрхийлэх боломжгүй байх нь тэдний хувьд жинхэнэ там.

### ***Шинэ сэтгэгдэл хайгч***

Аялал зугаалгад дуртай, кино концерт, номноос сэтгэлийн их эрч хүч авдаг.

*Тэд асуудал үүсэхийг хүлээж суудаггүй, эргэн тойрноосоо элдэв шинэ санаа, оригинал шийдэл эрж хайж байдаг хүмүүс (Б.М).*

### ***Эрсдэлээс ухардаггүй***

Бусдын санаанаас үл хамаарч, эрсдэлтэй алхам хийхээс буцдаггүй улс. Хүний хийгээгүйг хийж, туулаагүй замыг туулах сонирхолтой байдаг. Тиймдээ ч тэд орчин тойронтойгоо “асуудал”-тай байх нь олонтаа. Амьтдаа нэр алдарт хүрээгүй ч нас барсан хойноо хүлээн зөвшөөрөгдсөн их бүтээлчид зөндөө байдаг билээ.

*Бүтээлч хүмүүс аливааг өөр өндрөөс, өөр өнцгөөс харах хандлагатай. Тэд ямар нэг зүйлийн далд шинжийг олж таниад өөр зорилгоор, илүү үр дүнтэй ашиглах хувилбарууд гаргахдаа гаргуун улс (Б.М).*

### ***Алдаан дээрээ суралцах чадвар***


Эдисон Гэрлийн ламп зохион бүтээдээ 10,000 дахин оролдлого хийсэн гэдэг. Шинэ зүйл бүтээж буй хүний дагуул нь чухамдаа алдаа. Харин бүтээлч хүмүүс алдаан дээрээ байнга суралцан, ахин алдахгүйн зэрэгцээ *алдаанаасаа дараагийн шинэ зүйлийг олж харах*, урагшлах урам зоригтой хүмүүс байдаг. Алдаа нь тэдний туршлагыг зузааруулж, шинийг эрэлхийлэгч, бүтээлч чанарыг нь улам бүр хурцалдаг.

### ***Мөрөөдөл, хүслийн дуудлагатай***

Бүтээлч хүмүүс бусдад харагдах гэж, шагнал, нэр хүндийн төлөө ажилладаггүй. Тэд бүтээж, зохиож буй хөдөлмөрөөсөө, шинэ бүтээлээсээ асар их аз жаргал, кайф авдаг болохоор цаг хугацааны мэдрэмжээ алдан өдөр шөнөгүй зүтгэх нь энүүхэнд. Дуртай, хүсч мөрөөдөж буй зүйлээ нойр, хоолгүй хийдэг ч түүнээсээ болж ядарч зовох, өвдөж шаналахыг ч мэдэрдэггүй чанар тэдэнд бий.

Сэтгэл судлалд хүмүүсийг төрөлхийн зан араншингаар нь Флегматик, Сангвиник, Холерик, Меланхолик гэж ангилж үздэгийг бид мэднэ. Мэдээж 100% нэг төрлийн араншинтай хүн ховор. Жишээ нь 100% меланхолик бол хэцүүднэ биз дээ. Бид ихэнхдээ эдгээр араншингийн аль альнаас нь авч төрдөг.

Та ямар ч төрөлхийн араншинтай бай, бүтээлч чанар танд байгаа, бас түүнийгээ цаашид хөгжүүлж болно.



## ТЕМПЕРАМЕНТЫ ИЗВЕСТНЫХ ЛИЧНОСТЕЙ

МЕЛАНХОЛИКИ			ХОЛЕРИКИ		
Писатель Н. Гоголь	Поэт А. Блок	Поэт М. Лермонтов	Полководец А.В.Суворов	Писатель А.С.Пушкин	Царь Петр I
ФЛЕГМАТИКИ			САНГВИНИКИ		
Учёный И.Ньютон	Баснописец И.А. Крылов	Полководец М.И. Кутузов	Композитор В. Моцарт	Актёр Е. Леонов	Писатель А.И. Герцен

### Дасгал ажил:

Дээрх алдартнуудын хувийн зан араншинг уран бүтээл, нийгэм улс төрийн амьдралд гаргасан үйлстэй нь харьцуулж ярилцах. Улмаар өөрсдийгөө болон ойр дотны хүмүүсээ ч сонирхон судалж, таамаглал дэвшүүлж болно!

## V. ДААЛГАВАР

### Зөвлөмж:

Сэтгэлгээний хэв маягуудыг сэтгэл судлал, боловсрол судлалын салбарын ном сурах бичиг, судалгааны ажлуудаас дэлгэрүүлж судлан бүтээлч сэтгэлгээний талаарх суурь ойлголтоо бататгаж аваарай. Өөрөө судалж ойлгосон мэдлэг мартагддаггүйг анхаараарай!

*Гүйцэтгэх бүтээлч ажил:*

1. Зураач уран бүтээлчдийн алдартай бүтээлүүдийн бүтээгдсэн түүхийг судлан, бүтээлээр нь дамжуулж бүтээлч үйл ажиллагааны онцлогийг тодруулах туршилт хийж, баг хамт олноороо хэлэлцүүлээрэй !

(хүн тус бүр 3 бүтээл судлан өөрсдийн бүтээл туурвих үйл явцтай харьцуулж тайлбарлах)

2. Дараах бэлэн загварт дүн шинжилгээ хийх (шүүмжит сэтгэлгээгээр хандаж, өөрсдийн саналаа дэвшүүлж ярилцах )



[Эх сурвалж: http://www.mlctraining.mn/b/2279](http://www.mlctraining.mn/b/2279)

**АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!**